



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар A/115

Улаанбаатар хот

Авто зам эзэмших эрх олгох тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын чанартай АНЗ дугаартай Улаанбаатар-Чойр, Улаанбаатар-Дархан, АН32 дугаартай Улаанбаатар-Өндөрхаан, Улаанбаатар-Арвайхээр, улсын чанартай А0201 дугаартай Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас Улаанбаатар хотын замын хөдөлгөөн зохион байгуулалттай уялдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн эзэмшилд шилжүүлэх авто замын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Эзэмшилд шилжүүлэн авсан авто зам, замын байгууламжийг хүлээн авч, зам хариуцагчийг тогтоож, авто замын засвар, арчлалтын ажлыг зохион байгуулж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 187 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2023 оны 04 дугаар сарын 26 өдрийн
А/115 дугаар тушаалын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ЭЗЭМШИЛД
ШИЛЖҮҮЛЭХ ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ХЭСЭГ

Д/Д	Авто замын ангилал, чиглэлийн дугаар	Замын нэр	Нийслэлд эзэмшүүлэх замын урт (км)	Эхлэл цэгийн		Төгсгөл цэгийн	
				Солбицол	Байрлал	Солбицол	Байрлал
1	АНЗ, А0101	Улаанбаатар-Чойр	30.1	47°55'0.59"N 106°54'58.39"E	Монгол Улсын авто замын сүлжээний эхлэлийн цэг Км 0+000	47°46'38.17"N 107°13'56.44"E	Налайх-Чойрын уулзвар хүртэл /Уулзвар өнгөрөөд Чойрын замын эхлэл цэг/ АНЗ, А0401
2	АНЗ, А0401	Улаанбаатар-Дархан	18.8	47°55'0.59"N 106°54'58.39"E	Монгол Улсын авто замын сүлжээний эхлэлийн цэг Км 0+000	47°55'34.14"N 106°37'17.19"E	АНЗ, А0401 чиглэлийн км 19+000, тойрог уулзварын баруун хойно
3	АНЗ, А0501	Улаанбаатар-Өндөрхаан	1.2	47°47'23.21"N 107°13'7.79"E	АНЗ, А0101 чиглэлийн км 29+200, Налайхаас нийлэх нарийн зам болон гол замын уулзвар цэг	47°47'19.41"N 107°13'59.94"E	Налайхын зам, эхлэл цэгээс 1.2 км-т
4	АНЗ, А0301	Улаанбаатар-Арвайхээр	15.4	47°53'54.89"N 106°39'59.93"E	АНЗ, А0401 чиглэлийн км 19+000, тойрог уулзварын баруун урд	47°54'4.02"N 106°29'45.55"E	4 эгнээ бүхий өргөн авто замын төгсгөл
5	А0201	Улаанбаатар-Мандалговь	24.7	47°55'0.59"N 106°54'58.39"E	Монгол Улсын авто замын сүлжээний эхлэлийн цэг Км 0+000	47°46'0.07"N 106°44'46.45"E	Түргэний гүүр хүртэл /Түргэний гүүр орохгүй./